



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 37

Улаанбаатар хот

Г Хөрөнгө бүртгэлээс хасах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:


1. Нийслэлийн Засаг даргын захирамжаар дүүргийн Гэр бүл хөгжлийн төвд барилгын зориулалтаар газар олгосонтой холбогдуулан ашиглалтын шаардлага хангахгүй болсон 22834100 (хорин хоёр сая найман зуун зучин дөрвөн мянга нэг зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий Чингэлтэй дүүргийн 13 дугаар хорооны өрхийн эмнэлгийн барилгыг буулгаж, дүүргийн өмчийн бүртгэлээс хасахыг дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/-д зөвшөөрсүгэй.


2. Хөрөнгийн хөдөлгөөнд холбогдох дүрэм, журмын дагуу хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/-д даалгасугай.


ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ









Боловсруулсан: *Ч. Анхшилт*  
Хянасан: *Р.Сүхмөр*  
Хувь: 27.  
20.11.05 сар 30 өдөр



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 39

Улаанбаатар хот

**Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг  
шинэчлэн байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Нийслэлийн Чингэлтэй дүүрэг, Япон Улсын Нийгата муж, Госен хот хоорондын найрамдалт хамтын ажиллагааны хүрээнд бизнес, соёлын өдөрлөгийг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Одбаяр

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга

Нарийн бичгийн дарга:

Ц.Алтанцацрал

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга

Гишүүд:

Т.Уламбаяр

Хурлын Ажлын албаны Иргэний оролцооны хэлтсийн дарга

Г.Ундрал

Хурлын Ажлын албаны Зохион байгуулалтын хэлтсийн дарга

Б.Мөнгөнсүх

Захиргаа, хуулийн хэлтсийн дарга

Д.Булган

Худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга

С.Энхтайван

Чингэлтэй бизнес инкубатор төвийн захирал

С.Амарбаясгалан

Чингэлтэй дүүргийн 5 дугаар хорооны Засаг дарга

Ш.Жаргалсайхан

Чингэлтэй дүүргийн 16 дугаар хорооны Засаг дарга

Н.Янжинлхам

Хурлын Ажлын албаны зохион байгуулалтын хэлтсийн хэвлэл мэдээлэл,

Я.Орломсүрэн

гадаад, дотоод харилцаа, хамтын  
ажиллагаа хариуцсан ажилтан  
Нийгмийн хэлтсийн соёл, урлаг хариуцсан  
ахлах мэргэжилтэн

2. Өдөрлөгийн бэлтгэл ажлыг сайтар хангаж, удирдлага зохион байгуулалтаар хангаж, бэлтгэл ажлын төлөвлөлт, явцын талаарх мэдээ, тайланг нэгтгэн 2014 оны 06 дугаар сарын 25-ны дотор Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Д.Одбаяр/-т даалгасугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 56 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ





**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 40

Улаанбаатар хот

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн хэмжээнд нийгмийн дэг журмыг бэхжүүлэх зорилгоор нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй нийтийн байрны үйл ажиллагааг журамлах “Чингэлтэй дүүргийн нийтийн байрны ашиглалт, үйлчилгээний журам” боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:  
Д.Одбаяр

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга

Нарийн бичгийн дарга:  
С.Туяа

Дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга

Гишүүд:

Ц.Ганболд

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч

А.Дамцагдорж

Дүүргийн онцгой байдлын хэлтсийн дарга

Б.Батчимэг

Дүүргийн мэргэжлийн хяналтын хэлтсийн дарга

М.Алтансүх

Дүүргийн өмч, газрын харилцааны албаны дарга

Б.Лхагвасүрэн

Дүүргийн дэд бүтэц, тохижилтын хэлтсийн дарга

Г.Эрхэмбаяр

Дүүргийн цагдаагийн 1 дүгээр хэлтсийн дарга

Х.Хадбаатар

Дүүргийн цагдаагийн 2 дугаар хэлтсийн дарга

2. Журмын төслийг 2014 оны 06 дугаар сарын 15-ны дотор боловсруулан, Хурлын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэхийг ажлын хэсгийн ахлагч /Д.Одбаяр/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 41

Улаанбаатар хот

Шагналд уламжлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улсад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа зарим хүмүүсийн хөдөлмөр бүтээлийг үнэлж, Төрийн дээд шагнал, цол, одон медалиар шагнуулахаар тодорхойлсон байгууллага, хамт олны саналыг дэмжиж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд уламжилсугай. Үүнд:

“МОНГОЛ УЛСЫН СОЁЛЫН ГАВЪЯАТ ЗҮТГЭЛТЭН ЦОЛ”-ООР

- |                           |  |
|---------------------------|--|
| 1. Дамдинсүрэнгийн Цэдмаа | Музейн шинэ хөгжил, нийгэмлэгийн тэргүүн |
| 2. Рэгзэнгийн Чулуунцэцэг | Лавайн эгшиг радиогийн ерөнхий редактор  |

“МОНГОЛ УЛСЫН АЖ ҮЙЛДВЭРИЙН ГАВЪЯАТ АЖИЛТАН ЦОЛ”-ООР

- |                      |   |
|----------------------|---|
| 1. Даржаагийн Пүрвээ | Сүү, цагаан идээний үйлдвэрлэлийг дэмжих үндэсний “Цагаан далай сан”-гийн тэргүүн |
|----------------------|---|

“МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ГАВЪЯАТ ЦОЛ”-ООР

- |                     |   |
|---------------------|---|
| 1. Дүгэржавын Готов | Монголын Авто инженерүүдийн холбооны өндөр настан |
|---------------------|---|

“МОНГОЛ УЛСЫН ГАВЪЯАТ ЭДИЙН ЗАСАГЧ ЦОЛ”-ООР

- |                          |                                     |
|--------------------------|-------------------------------------|
| 1. Пирэн-Аагийн Цэрэнбат | “Алаг даага” ХХК-ийн нягтлан бодогч |
|--------------------------|-------------------------------------|

2. Аюушийн Бааст

Монголын газар зохион байгуулагчдын  
холбоо ТББ-ын өндөр настан

“МОНГОЛ УЛСЫН ГАВЪЯАТ БАГШ ЦОЛ”-ООР

1. Доржийн Амар

Монголын ахмад багш нарын холбооны  
тэргүүн, профессор

“МОНГОЛ УЛСЫН ГАВЪЯАТ БАРИЛГАЧИН ЦОЛ”-ООР

1. Лувсандамдингийн Бямбасүрэн

Нийслэлийн зураг төслийн хүрээлэнгийн  
зөвлөх архитектор

2. Самбуугийн Цахиур

Нийслэлийн зураг төслийн хүрээлэнгийн  
дарга

3. Готовын Нарангэрэл

Нийслэлийн зураг төслийн хүрээлэнгийн  
ерөнхий инженер

“ХӨДӨЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОН ”-ГООР

1. Нэргүйн Оюунгэрэл

Чингэлтэй дүүргийн тохижилт үйлчилгээ  
ХХК-ийн ерөнхий захирал

2. Дашдондовын Цооз

Монголын үндэсний музейн харуул

3. Найдангийн Дудаарий

“Кон-инженерс” ХХК-ийн барилгын зураг  
төслийн зөвлөх инженер

4. Цэрэндоржийн Чойнхор

“Жэмр” ХХК-ийн менежер, зөвлөх

5. Цэрэндоржийн Цэрэнбалжир

Шинжлэх ухааны академи геоэкологийн  
хүрээлэнгийн өндөр настан

6. Доржийн Болд

Монголын эрчим хүч, геологи, уул уурхай  
үйлдвэрчний эвлэлийн нарийн бичгийн  
дарга

7. Пунцагдоржийн Эрдэмбат

Байгалийн түүхийн музейн өндөр настан

8. Агваанжамбын Ариунболд

Капитал банкны гүйцэтгэх захирал

9. Шаравдоржийн Норжмаа

Капитал банкны Дархан-Уул аймгийн  
салбарын захирал

10. Сэрээтэрийн Бямбаа

Нийслэлийн Татварын газрын татварын  
улсын байцаагч

11. Должинсүрэнгийн Тогтохбаяр

Монголын хэрэглэгчийн академийн  
ерөнхийлөгч

“СҮХБААТАРЫН ОДОН”-ГООР

1. Бизьяагийн Дашзэвэг

Зохиомж дээд сургуулийн багш

“ЦЭРГИЙН ГАВЪЯАНЫ ОДОН”-ГООР

1. Буяндэлгэрийн Булган

Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хорооны  
өндөр настан

## “АЛТАН ГАДАС ОДОН”-ГООР

- |                               |   |
|-------------------------------|---|
| 1. Буяндэлгэрийн Тунгалаг     | Нийслэлийн зураг төслийн хүрээлэнгийн төлөвлөлт судалгааны хэлтсийн ахлах мэргэжилтэн |
| 2. Чойдоржийн Чулуунбаяр      | Чингэлтэй дүүргийн 10 дугаар хорооны өндөр настан                                     |
| 3. Чойрогийн Лувсанжамц       | Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хорооны өндөр настан                                     |
| 4. Санжаагийн Нямсүрэн        | Чингэлтэй дүүргийн 10 дугаар хорооны өндөр настан                                     |
| 5. Доржийн Энхтөгс            | Монголын үндэсний музейн мэргэжилтэн  |
| 6. Гомбодоржийн Ичинхорлоо    | “Бумбат зүрх” ХХК-ийн захирал   |
| 7. Төмөрийн Мөнхбат           | Монголын газар зохион байгуулагчдын холбоо ТББ-ын өндөр настан                        |
| 8. Цэрэндоржийн Ширчинжав     | Монголын газар зохион байгуулагчдын холбоо ТББ-ын өндөр настан                        |
| 9. Толягийн Лхагвасүрэн       | Баялаг Увс ХХК-ийн газар зохион байгуулагч, геодези хариуцсан захирал                 |
| 10. Хуягийн Цэцэгбадам        | Нийслэлийн тээврийн газрын өндөр настан   |
| 11. Жамбаажамцын Цогтбаяр     | Байгалийн түүхийн музейн эрдэм шинжилгээний ажилтан                                   |
| 12. Гомбын Цэрэндолгор        | Байгалийн түүхийн музейн өндөр настан   |
| 13. Гомбодоржийн Уламбаяр     | Байгалийн түүхийн музейн өндөр настан   |
| 14. Дамдиндоржийн Өлзиймандах | Капитал банкны Хөвсгөл аймгийн салбарын захирал                                       |
| 15. Дуламсүрэнгийн Цэенрэгзэн | Капитал банкны Завхан аймгийн салбарын захирал  |
| 16. Сандагийн Туул            | Капитал банкны Аж ахуйн мэргэжилтэн   |
| 17. Лүнгээгийн Эрдэнэбат      | Нийслэлийн зураг төслийн хүрээлэнгийн Тамгын хэлтсийн дарга                           |
| 18. Махранзын Эрдэнэцэцэг     | Нийслэлийн зураг төслийн хүрээлэнгийн хот төлөвлөлтийн инженер                        |
| 19. Онгорхойн Дуламжав        | Увс аймгийн Зүүнхангай сумын Ахлах сургуулийн захирал асан                            |

## “ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛЬ”-ИАР

- |                        |   |
|------------------------|---|
| 1. Баттөмөрийн Жавзан  | Чингэлтэй дүүргийн тохижилт үйлчилгээ ХХК-ийн зам талбайн инженер |
| 2. Чигсэмийн Туулцэцэг | Монголын үндэсний музейн эрдэм шинжилгээний ажилтан               |

- |                                |   |
|--------------------------------|---|
| 3. Цанжидын Оюунхишиг          | Монголын үндэсний музейн олон нийттэй харилцах маркетингийн ажилтан                                     |
| 4. Үржингийн Баасанжав         | Монголын үндэсний музейн үзмэр харагч   |
| 5. Цэвээндоржийн Эгиймаа       | Монголын үндэсний музейн эрдэм шинжилгээний ажилтан   |
| 6. Цэрэндоржийн Одбаатар       | Монголын үндэсний музейн эрдэм шинжилгээний ажилтан   |
| 7. Дашцэрэнгийн Отгонбаяр      | Дүрслэх урлагийн музейн үзмэр харагч  |
| 8. Рэгдэндагвын Гантуяа        | Дүрслэх урлагийн музейн тасалбар түгээгч  |
| 9. Дамбын Дүгэрсүрэн           | Чингэлтэй дүүргийн 15 дугаар хорооны өндөр настан   |
| 10. Дэмбэрэлийн Баяраа         | Чингэлтэй дүүргийн 10 дугаар хорооны өндөр настан   |
| 11. Базаррагчаагийн Бадамцэцэг | Байгалийн түүхийн музейн эрдэм шинжилгээний ажилтан   |
| 12. Тогтоохоны Тодгэрэл        | Байгалийн түүхийн музейн сан хөмрөгийн тасгийн дарга  |
| 13. Жамбалдоржийн Мяндас       | Байгалийн түүхийн музейн дэд захирал  |
| 14. Цэрэндоржийн Мөнхжаргал    | Нийслэлийн Татварын газрын татварын улсын байцаагч  |
| 15. Мажаагийн Оюунчимэг        | Нийслэлийн Татварын газрын татварын улсын байцаагч  |
| 16. Дуламжавын Мөнхтогоо       | Монголын үндэсний музейн арга зүйч  |
| 17. Даваасүрэнгийн Лхамсүрэн   | Чингэлтэй дүүрэг дэх маргэжлийн хяналтын хэлтсийн эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч |

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

## ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Үйлчилгээ үзүүлэх байгууллагын нэр: ЧД-ийн 16-р хороо

Нийгмийн ажилтан: Г Оюунцэцэг

Үйлчлүүлэгчийн код: 20

### **НЭГ. а) Үйлчлүүлэгчийн товч бүртгэл**

1. Овог нэр: Адъяа
2. Нэр: Батэлзий
3. Нас 57
4. Хүйс эр
5. Төрсөн он сар өдөр: 1957-05-01 РД: / ЧК57050175/
6. Харьяалал \ Үндсэн захиргаа \ Завхан аймаг Орхон сум

Одоогийн оршин сууж буй хаяг: ЧД-ийн 16-р хороо согоот 31-395 тоот

### **б) Үйлчлүүлэгчийн талаарх анхны үнэлгээ**

1. Гадаад төрх байдал: Үйлчлүүлэгчийн биеийн байдал шаналсан, зовсон шинжтэй. Бие муутай, хэвтэрт гэр бүлдээ санаа зовсон.
2. Үйлчлүүлэгчийн зан харьцаа \ үг ярианы байдал, харилцах байдал \ Үйлчлүүлэгч бие муу, хэвтэрт тул хүнтэй ярихдаа муухан ярьдаг.

### **в) Гэр бүлийн нийгэм эдийн засгийн байдал \ дүрслэн тэмдэглэх, гэр байр хувийн хөлсний \ өөрийн гэрт**

1. Үйлчлүүлэгч А. Батэлзий нь тус хорооны согоотын 31-395 тоотод ам бүл 13 нөхөр, хүүхдийн хамт Дамбадаржаад түрээсний байшинд амьдарч байна.
2. Орлого \ эх үүсвэрүүд нөөц боломж, гарын ур дүй гэх мэт\ Тэтгэврийн мөнгө 2 хүний -414,000 төгрөг, хүүхдүүдийн хувиараа жижиг наймааны орлого-500,000 төгрөг
3. Зарцуулалт \ амьдралын түвшин тааруу, өрхийн орлого зарлагаа хянаж чаддаг.
4. Өмнө нь ямар нэг байгууллагаас тусламж авч байсан эсэх: Тусламж дэмжлэг авч байгаагүй.
5. Хорт зуршил \Гэр бүлийн хэн нэгэн архи тамхи мансууруулах бодис хэрэглэдэг эсэх: Архи тамхи хэрэглэдэггүй.
6. Гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндийн байдал \ Удамшлын ямар нэгэн өвчин эмгэг бүү эсэх\ Удамшлын өвчин байхгүй. Үйлчлүүлэгч биеийн байдал муу, Баруун

гарын шуу хугархай, зүүн талын хөлний дунд чөмөгний толгой хайлсан. Одоо хэвтэрт, гэрээрээ өвчин намдаах эмчилгээ хийлгэдэг.

7 Гэр бүлийн талаархи харьяа орон нутгийн засаг захиргааны хүмүүсийн мэдээлэл:

Тус хорооны хэсгийн ахлагч болон хөршүүдийн мэдээллээр тус хороонд 1998 оноос хойш амьдарч байгаа. Биеийн байдал муу, хэвтэрт байдаг, явж чаддаггүй. Хүү Ганэрдэнэ зам тээврийн осол гарган хашаа байшингаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хураалгасан гэсэн мэдээлэлтэй. А. Батэлзийгийн эхнэр Ш. Цэцэгбал дүүрэг, хорооны ажилд маш идэвхитэй оролцдог.

#### **г\ Үйлчлүүлэгчийн гэр бүлийн байдал**

1. Ам бүлийн түүх \ хэн хэн амьдардаг хаана юу хийдэг болох \ Ам бүл-13 нөхөр, хүүхдүүдийн хамт амьдардаг. Үйлчлүүлэгч А. Батэлзий улсад нийт 27 жил ажиллаж байгаад 2006 онд группт орсон. Үүнд: ТИС-д багшаар 1995-2005 онд ажиллаж байсан. Барилгын 3-р ТМС-д 1980-1990 онд багш, 1992-2005 он хүртэл ТИС-ийн барилга инженерийн лицейд мужааны мастер багшаар, 2008-2010 он ТМС-д тус тус багшилж байсан.

Хаана амьдардаг \ Гэрийн хаяг холбоо барих утас \

ЧД-ийн 16-р хорооны согоотын 25-342в Холбогдох утас: 88939067, 99839067

2. Ам бүлийн орлого \ эх үүсвэр \ Тэтгэврийн мөнгө 2 хүний- 414,000 төгрөг тогтмол бус орлого -500,000 төгрөг, нийт -914,000 төгрөг
3. Амьдралын нөхцөл байдал \ гэрт байшин гэх мэт\ Амьдралын нөхцөл тааруу, нийгмийн тусламж дэмжлэг зайлшгүй шаардлагатай өрх бөгөөд А. Батэлзий өөрийн эзэмшлийн 11х6 хэмжээтэй хашаа байшинтай байсан боловч хүү Ганэрдэнэ 2012 оны 10-р сарын 09-ний өдрийн 02 цагт УНП улсын дугаартай Форд маркийн авто машинтай мөргөлдөж зам тээврийн осол гаргасан. Үүнээс хойш торгуулийн 700,000 төгрөг, шүүхийн шийдвэрт гүйцэтгэх газарт 1,800,000 төгрөг төлсөн. 2014 оны 5-р сарын 23-ны өдөр үлдсэн 21,534,650 төгрөгний торгуульд хашаа байшингаа хураалгасан. Одоо нөхөр хүүхдүүдийн хамт Дамбадаржаад түрээсний байшинд олуулаа амьдарч байна.

**ДӨРӨВ.**

#### **НИЙГМИЙН АЖИЛТНЫ ТЭМДЭГЛЭЛ**

##### **1. Нийгмийн ажилтанд хандах болсон шалтгаан**

Үйлчлүүлэгч А. Батэлзий нь 57 настай дээд боловсролтой, олон жил багшийн ажил эрхэлсэн. 2010 онд баруун гарын шуу хугарч группт орсон, зүүн талын хөлний дунд чөмөгний толгой хайлж явж чадахаа больсон. Одоо хэвтэрт, эмнэлэг болон

гэрээрээ өвчин намдаах эмчилгээ хийлгэдэг. Маш хүнд өвчтэй, санхүүгийн хувьд хүндрэлтэй байгаа мөн шүүхийн шийдвэрээр хашаа байшингаа хураалгаж орон гэргүй болсон гэх мэт шалтгааны улмаас орон гэр хүссэн өргөдөл гаргасан.

#### 1. Үйлчлүүлэгчид тулгарч буй бэрхшээл асуудал:

- Үйлчлүүлэгч А. Батэлзий нь зүүн хөлний дунд чөмөгний толгой хайлсны улмаас хэвтэрт орсон. Эмчилгээний төлбөрт маш их мөнгө шаардлагатай. Тухайн өрхийн амьдралын байдал 2 хүний тэтгэврийн мөнгөнөөс өөр тогтмол орлогогүй
- Хашаа байшинг нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар хүү Ганэрдэнэ зам тээврийн осол хийсний улмаас 21,534,650 төгрөгний торгуульд хураалган өөрийн гэсэн орон гэргүй болсон нь тулгарч буй маш хүнд бэрхшээл болоод байна.

#### 2. Үйлчилгээ үзүүлсэн байдал:

Нийгмийн ажилтан тухайн гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээг хийхийн тулд дараах үйлчилгээг үзүүлсэн. Үүнд:

- Үйлчлүүлэгчийн амьдарч буй газар нь очиж нөхцөл байдалтай нь танилцсан.
- “Тэгш өлзий” өрхийн эрүүл мэндийн төвд тухайн үйлчлүүлэгчийг хариуцсан эмчтэй нь уулзаж биеийн байдлыг тодруулж цаашид ямар эмчилгээ хийлгэх шаардлагатайг тодруулсан.
- Ахмад настны нийгмийн халамжийн хууль тогтоомж, хөнгөлөлт болон бусад нөөц бололцооны талаар зөвлөгөө өгсөн.

#### НИЙГМИЙН АЖИЛТНЫ САНАЛ, ТЭМДЭГЛЭЛ :

Үйлчлүүлэгч Адъяа овогтой Батэлзий нь 57 настай, тус хороонд 1998 оноос хойш тус хороонд амьдарч байгаа. Олон жил багшийн эрхэлсэн дээд боловсролтой ахмад настан бөгөөд 2010 оноос бие нь муудаж хэвтэрт орсон. Мөн хашаа байшинг нь 21,564,650 төгрөгний торгуульд шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар хурааж авсан тул өөрсдийн гэсэн орон гэргүй болж 13 ам бүлийн хамт Дамбадаржаад айлын түрээсний байшинд амьдарч байна. Иймээс дээрх өрх, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой, тэтгэврийн мөнгөнөөс өөр тогтмол орлогогүй, хүүхдүүд нь гар дээрээс гудамжинд жижиг бараа зардаг боловч энэ нь тогтмол бус, хэвтрийн өвчтэй хүнтэй учир эм тарианы мөнгөнд өрхийн орлого нь хүрэлцдэггүй гэх мэт шалтгааны улмаас нийгмийн тусламж дэмжлэг зайлшгүй шаардлагатай өрх тул тусламж дэмжлэг, орон гэр олгуулах саналтай байна.

НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ ГАРГАСАН:

16 ДУГААР ХОРООНЫ НИЙГМИЙН АЖИЛТАН *Dame* Г. ОЮУНЦЭЦЭГ



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН 16 ДУГААР ХОРООНЫ  
АМЬЖИРГААГ ДЭМЖИХ ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2014.06.04

№ 10

Улаанбаатар хот

1.хурал 13 цаг 30 минутанд хорооны нэг цэгийн үйлчилгээний өрөөнд болсв.

ХУРАЛД:

**ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
ГИШҮҮД**

**Г.ОЮУНЦЭЦЭГ  
М.САРАНТУЯА  
Б.УЛАМБАЯР  
Б.ЦЭРЭНДУЛАМ  
Б. МАХЗАНДАР**

**2.ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ :** Байнгын асаргаа 3 иргэн, тэжээгчээ алдсан 1 иргэн, эм тарианд хамрагдах 1 иргэн, гэнтийн аюул ослийн улмаас гэр орон нь шатсан иргэнд гэр авхад нь туслах буцалтгүй тусламж 2 иргэн, гэр оронгүй ажилгүй тэнмэл иргэнд гэр авхад нь туслах тусламж 1 иргэн, Чингэлтэй дүүргийн Иргэдийн нийтийн хуралд гэр хүссэн 1 өрх- иргэний хүсэлтийг тус тус хэлэлцэнэ.

**3.ХЭЛЭЛЦСЭН НЬ :** М.Сарантуяа: Гомборагчаа овогтой Нүрдүүрмаа нь хорооны 75-1035 тоот оршин суудаг. Тэрээр цусны даралт ихсэх өвчтэй нас өндөр гарсан, эмч нарын хяналтанд байх болсон байна. Иймээс эм тарианы хөнгөлтөнд хамруулж өгнүү гэсэн өргөдөл гаргасан байна.

Нансалмаа овогтой Ханбулаг нь согоотын 49-563 тоотод оршин суудаг одоо 3 сартай. Тэрээр төрөхдөө төрөлхийн хошноого битүү гэсэн оноштой бие засж чаддагүй, хүндэрч чадахгүйн улмаас байнгын баасны хордлогонд ордог, эмч нарын байнгын хяналтанд байх болсон. Одоо түүнийг ээж болох Цэвээн овогтой Дулмаа асарч байгаа тул байнгын асаргаанд оруулах хүсэлт гаргасан байна.

Б. Уламбаяр : Мижид овогтой Эрдэнэцэцэг нь согоотын 17-237тоот оршин суудаг. 56 настай. Тэрээр 2002 оноос группд орсон 80% ХЧА-тай булчингийн суурал гэсэн оноштой одоо биеийн байдал дордоод хөл гар сулраад хүний ажиргаанд орсон. Одоо түүнийг хүү болох Ганбаатар овогтой Бямбажав асарч байгаа. Иймээс асаргаанд оруулхаар хүсэлт гаргасан байна.

Гомбо овогтой Нэргүй нь согоотын 4-58 тоот оршин суудаг. 59 настай эмэгтэй. Тэрээр биеийн байдал муу хөл гар муу, юм сайн ярьж чадахгүй нүдэнд юм торж сайн харж чадахгүй. Одоо түүнийг хүү болох Баяраа овогтой Тайванбаяр нь асарч байгаа. Иймээс асаргаанд оруулхаар хүсэлт гаргасан байна.

Ботболд овогтой Оюун-эрдэнэ нь согоот 78-1083 тоотод оршин суудаг. 2014 оны 02 сарын 26-ны өдөр тус тус газар байсан 5 ханатай гэр нь шатсан бөгөөд гал гарах үед 10 сар, 2 нас, 6 настай 3 хүүхэд байсан бөгөөд уг гал түймэрт 10 сартай хүү нь нас байсан байна. Одоо Б.Оюунэрдэнэ нь орох орон гэргүй болсон тул Баянхошуунд айлд түр амьдарч байгаа юм байна. Иймд тус өрхөд гарсан гарз хохирлыг харгалзан үзэж гэр авахад нь зорулж 1 удаагийн буцалтгүй тусламж хүссэн байна.

Н/Б/Д: Г.Оюунцэцэг : Тус айл нь нэн ядуу, дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрт тул хүсэлтийг дэмжиж байна.

Бойр овогтой Ариунжанаа нь согоотын 17-241 тоотод оршин суудаг. 2014 оны 2 сарын 14 ны өдөр цахилгааны улмаас гал гарч нөхөр Б.Баяр нь нас барсан. Тэрээр одоо 3 охин зээгийн хамт хүргэнийхээ гэрт түр амьдарч байгаа. Иймийн учир гэр авахад нэг удаагийн буцалтгүй тусламжинд хамруулхаар хүсэлт гаргасан байна.

Дашням овогтой Энхцацрал нь согоотын 4-63а тоотод оршин суудаг. Тэрээр нөхөр болох Бат-Очир овогтой Эрдэнэбилэг нь өвчний учир 2014 оны 05 сарын 08 өдөр нас барсан. Нөхөр ардын эрх сонины Эрэл компанд ажиллаж байсан боловч ажилласан жил НД-аас тэжээгчээ алдасны тэтгэмж авхад ажилсан жил хүрэхгүй байгаа. Түүний хүү болох Эрдэнэбилэг овогтой Жамбалдорж 4 настай ээжийн хамт хоцорсон. Иймээс тэжээгчээ алдасны тэтгэмж тогтоох хүсэлт гаргасан байна.

Сосор овогтой Эрдэнэбаатар нь согоотын 70-955 тоот оршин суудаг. 52 настай эрэгтэй. Тэрээр 2008 онд эхнэр хүүхдээсээ салсан бөгөөд салахдаа шүүхээр гэр оронг нь эхнэр хүүхдийн нэр дээр шилжүүлснээр гэр оронгүй тэнэмэл байдалтай амьдрах болсон. С. Эрдэнэбаатар нь тусалж дэмжих ах дүүгүй. Иймээс хууль тогтоомжийн дагуу нэг удаагийн буцалтгүй тусламжинд хамруулхаар хүсэлт гаргасан байна.

Адьяа овогтой Бат-Өлзий нь согоотын 31-395 тоот оршин суудаг, 57 настай байнгын асаргаанд байдаг. Тэрээр одоо хүүхдүүд ач, зээ нийлсэн ам бүл 13-уулаа Дамбадаржаад түрээсийн байшинд амьдардаг. Нэн ядуу, хүүхдүүд нь гар дээрээс худалдаа хийдэг хэдий ч амьдралд хүрэлцээ муутай байдаг. Тус өрх нь нийгмийн тусламж дэмжлэг зайлшгүй шаардлагатай өрх тул, орон гэр олгуулхаар Чингэлтэй дүүргийн иргэдийн нийтийн хуралд өргөдөл гаргасан байна.






Зөвлөлийн дарга: З.Ганбат: М.Сарантуяатай санал нэг байна татгалзах зүйл алга.

**4.ШИЙДВЭРЛЭСЭН НЬ :** Байнгын асаргаа 3 иргэн, тэжээгчээ алдсан 1 иргэн, эм тарианд хамрагдах 1 иргэн, гэнэтийн аюул ослийн улмаас гэр орон нь шатсан иргэнд гэр авахад нь туслах буцалтгүй тусламж 2 иргэн, орон гэргүй тэнэмэл

иргэнд гэр авахад нь туслах тусламж 1 иргэн тус тус материалыг бүрдүүлэн ЧД-ийн НХҮХ-т уламжлахыг халамжийн мэргэжилтэн М.Сарантуяа, Б.Уламбаярт даалгаж шийдвэрлэв.

Мөн ам бүл олон, орон гэргүй А. Бат-Өлзийгийн гэр авах хүсэлт гаргасан иргэний материалыг ЧД-ийн Иргэдийн төлөөлөгчийн хуралд материалыг хүргүүлэхээр нийгмийн ажилтан Г. Оюунцэцэгт даалгаж шийдвэрлэв.

Хурал 13 цаг 45 минутанд дуусав.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН	
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:	 18 М.САРАНТУЯА
ХЯНАСАН:	 Г.ОЮУНЦЭЦЭГ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:	 Б.УЛАМБАЯР
ГИШҮҮД	 Б.ЦЭРЭНДУЛАМ
1	 Е.МАХЗАНДАР
2	
3	
4	
5	